



НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 015

Улаанбаатар хот

Нэмэгдэл хөлс олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.4 дэх хэсэг, 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.5 дахь заалт, Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 1.3.9 дэх заалт, Боловсролын сайдын 2025 оны 1/377 дугаар “Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх тухай зөвлөмж”-ийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах болсонтой холбогдуулан газрын албан хаагчдын монгол бичгээр зохион бүрдүүлсэн баримт бичгийг хянан, найруулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн нягтлан бодогч Содномдоржийн Ганчимэгт албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тооцож нэмэгдэл хөлс олгосугай.

2.Нэмэгдэл хөлсийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр тооцож олгохыг Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ